

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтыг тэргүүлэх чиглэл болгон, тус хөтөлбөрийн 3.1.2.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.” гэж, 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх...” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6.4-т “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.” гэж заасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан 2023 оны тоон мэдээллээс үзэхэд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 99 байгаагаас төрийн өмчит үйлдвэрийн газар 17 байна.

Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компани хэлбэрээр байгуулна.” гэж заасан бөгөөд төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, сум, нийслэл, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцох хуулийн зарчимтай.

Гэтэл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг Иргэний хуулийг зөрчиж тогтоосон нь тухайн төрлийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үйлчилж байгаа бусад эрх зүйн зохицуулалтад хийдэл үүсэх шалтгаан болж, улмаар хууль хэрэглээний практикт төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон хувийн хэвшлийн хуулийн этгээдэд ялгамжтай, тэгш бус хандах нөхцөлийг бүрдүүлж байна.

Өөрөөр хэлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит компаниас гадна аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн тооцоотой, эсхүл улсын төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар хэлбэртэй хуулийн этгээд байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг болсон нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжгүй, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд эдгээр үйлдвэрийн газрыг зохицуулах эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгааг цаг алдалгүй шийдвэрлэх буюу компанийн

хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байх хуулийн зохицуулалтыг бий болгох нь чухал байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газарт” гэснийг “төрийн өмчит компанид” гэж, 13 дугаар зүйлийн 2 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “төрийн өмчит компани” гэж, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрийн өмчит үйлдвэрийн газраас” гэснийг “Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь заалтад зааснаас” гэж, 22 дугаар зүйлийн “Төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “Төрийн өмчит компани” гэж, 60 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн өмчит үйлдвэрийн газрыг” гэснийг “төрийн өмчит компанийг” гэж тус тус өөрчлөх хэрэгцээ шаардлагын дагуу тус хуулийн төслийг боловсрууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15, 55 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай болон 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус дагалдуулан боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэхэд түлхэц болохын зэрэгцээ төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэхэд чухал алхам болно.

Түүнчлэн хуулийн этгээдийн хэлбэрийг Иргэний хуультай нийцүүлснээр хуулийн этгээдийн засаглал ойлгомжтой болох, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг хязгаарлах боломжийг бүрдүүлнэ.

---oOo---